



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд Г
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн 50 хувийн хувьцаа эзэмшигч Л.Болд нь өөрийн эзэмшлийн хувьцаанаас 495,000 ширхэг энгийн хувьцаа буюу компанийн нийт хувьцааны 9.899 хувийг “Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу “Богд банк” ХХК-д шилжүүлж, хавсралтад заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Бодь даатгал” ХХК /Б.Золбаяр/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 3 дугаар сарын 20-ны
өдрийн 35 дугаар тогтоолын хавсралт



“Бодь даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 1000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Л.Болд	2,500,272	2 500 272 000	50%	(495,000)		(495 000 000)	2,005,272	2 005 272 000	40.101%
2	Л.Болдхуяг	2,500,272	2 500 272 000	50%				2,500,272	2 500 272 000	50%
3	“Богд банк” ХХК	-	-	-	495,000	495 000 000		495,000	495 000 000	9.899%
4	Нийт	5,000,544	5 000 544 000	100%	-	495 000 000	(495 000 000)	5,000,544	5 000 544 000	100%